



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/52

Халбан

Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил  
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт, 8.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн гудамж, хороолол болон төвийн эргэн тойронд үүссэн хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2.Нарийн Ухаагийн хогийн цэгийн эргэн тойронд үүссэн хог хаягдлыг гар аргаар цэвэрлүүлэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулахыг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасагт үүрэг болгосугай.

3.Албан байгууллага, аж ахуй нэгж, хувийн хэвшил, иргэдийн цэвэрлэх талбайн хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:


Ажлын хэсгийн ахлагч: Б.Бямбажав (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүдэд: Д.Отгонжаргал (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Мөнх-Эрдэнэ (Халбан багийн Засаг дарга)

Б.Гүндсамбуу (Байгаль хамгаалагч)

Н.Цасанчихэр (Газрын даамал)

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.АНХБАЯР



Цэцэрлэг сумын Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 29-ны өдрийн 152 дугаар  
захирамжийн хавсралт

**АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙ НЭГЖ, ХУВИЙН ХЭВШИЛ, ИРГЭДИЙН ЦЭВЭРЛЭХ ТАЛБАЙН ХУВААРЬ**

№	Байгууллагын нэр	Хог тээвэрлэх машин	Хугацаа	Хамаарах нийтийн эзэмшлийн газар
1	ЗДТГ Хаан банк Төрийн банк "Хургатай хайрхан" ХХК	Хувийн машин	2024.05.03	Баярын талбайн урд талаас эхлэн хогийн цэгийн баруун хэсэг хүртэл
2	"Тэсийн илч" ХХК Соёлын төв Хувийн хэвшил	Хувийн машин	2024.05.03	Тэрэгтийн араас эхлэн хогийн цэгийн урд хэсэг хүртэл
3	ЕБС "Солонго" эмнэлэг ЭМТ	Хувийн машин	2024.05.03	Ухаагийн арын дунд дөрөлжөөс эхлээд Нарийн ухааг өвөрлөж хогийн цэгийн зүүн зах хүртэл
4	СӨБ Тусгай хамгаалалт газар Эрчим хүч Цаг уур	Хувийн машин	2024.05.03	СӨБ- Цэвэрлэх байгууламжийн урд талаас эхлэн Бурианы голын дунд гарам хүртэл Тусгай хамгаалалтын газар, Эрчим хүч, Цаг уур - Цэвэрлэх байгууламжийн зүүн талаас эхлэн Бурианы голын дунд гарам хүртэл
5	Хилийн цэрэг	Хогны машин	2024.05.02	Хогийн цэгийн эргэн тойрны хогийг хогийн цэгт ковшоор ачуулах